


UCS 1502B:2025

БАРИЛГЫН ХИЙЦ, ЭДЛЭХҮҮН, ТЕХНИК




Орон сууцны дээврийн ажилд тавигдах шаардлага

БАРИЛГЫН ХИЙЦ, ЭДЛЭХҮҮН, ТЕХНИК

Орон сууцны дээврийн ажилд тавигдах шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/09-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт	4
4. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага	4
5. Ерөнхий шаардлага.....	5
6. Дээврийн ажил гүйцэтгэх технологийн дараалал.....	8
7. Хуйлмал материалан дээвэр ба тусгаарлалт	10
8. Цийдмэг битумэн ба полимерен материалаар дээвэр ба тусгаарлалт хийх.....	12
9. Дулаалгын материалд тавигдах ерөнхий шаардлага.....	12
10. Ус тусгаарлалт	13
11. Шалгах хуудас	14
Ашигласан материалын жагсаалт.....	14

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Дээврийн төрөл ба төлөвлөлт.....	5
Зураг 2. Зөрүүлгийн хэмжээ.....	5
Зураг 3. Парпетны малгайвчны налуу.....	7
Зураг 4. Цоройлтын ирмэг болон малгайвч.....	10
Зураг 5. Бетон зуурмагийн тэгшилгээ	11

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Энгийн дээврийн ажлын технологийн дараалал	8
Хүснэгт 2. Бетон цутгалтын бэлтгэл ажлын технологийн дараалал	10
Хүснэгт 3. Дулаан тусгаарлах ноосон материалын техникийн үзүүлэлт	13
Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт	14



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 2509

Улаанбаатар хот

Барилгын хийц, эдлэхүүн, техникт
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Барилгын хийц, эдлэхүүн, техник” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS1501B:2025 “Орон сууцны барилгын дулаалга, гадна фасадад тавигдах шаардлага хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1502B:2025 “Орон сууцны дээврийн ажилд тавигдах шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

170.410.35

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



БАРИЛГЫН ХИЙЦ, ЭДЛЭХҮҮН, ТЕХНИК

UCS1502B2025

“ОРОН СУУЦНЫ ДЭЭВРИЙН АЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг орон сууцны дээврийн ажил гүйцэтгэхэд дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 31-07-05 Дээврийн ажил;
- БНБД 31-02-03 Дээврийн хучлага;
- MNS EN 13163:2011 “Барилгын дулаан тусгаарлах материал Хөөсөн полистрол (EPS) бүтээгдэхүүн. Техникийн шаардлага”;
- MNS 6227:2010, Барилгын дулаан тусгаарлах материал-Эрдэс хөвөн ба хөөсөн полистирол (PS) дулаалгатай олон үет төмөр хавтгайлж. Техникийн шаардлага.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Парпет – гэж хавтгай дээвэртэй барилгын дээврийн хучилтын хавтангаас дээш илүү гарсан бүтээц буюу ханын оройн хэсэг;

Уклон – гэж борооны ус зайлуулах гадаргуугийн налуу;

Корунд – гэж дулаан тусгаарлах зориулалттай, цагаан өнгөтэй өтгөрүүлсэн будаг;

Цэгэн болон зураасан замаар наах – гэж гадаргууг нийтэд нь бус нэг хэсгийг цавуудаж наах үйлдэл.

4. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. Дээврийг хийцийн хувьд дараах байдлаар ангилан төлөвлөнө. Үүнд:


- 4.1.1. Шувуун нуруун дээвэр /Налуутай дээврийг гол төлөв цөөн давхар /тав хүртэлх давхар/ барилгад төлөвлөнө;
- 4.1.2. Олон налуутай /Налуутай дээврийг гол төлөв цөөн давхар /тав хүртэлх давхар/ барилгад төлөвлөнө;
- 4.1.3. Хавтгай /Олон давхар, олон нийтийн, орон сууцны барилгад хавтгай дээвэр төлөвлөнө/.



Зураг 1. Дээврийн төрөл ба төлөвлөлт (жишээ зураг)

5. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 5.1. Гадаргууг сайтар цэвэрлэж бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна.
- 5.2. Уур, ус тусгаарлагч материал дэвсэх ба материалын бүтэн байдал хангах шаардлагатай.
- 5.3. Хөнгөн Дээврийн дулаалгыг барилгын зураг төсөлд заасны дагуу гүйцэтгэх бөгөөд холбогдох норм дүрэм, стандартын шаардлага хангасан дулаалгын материал ашиглана.
- 5.4. Хөнгөн блокийн нунтаг болон керамзитаар налуу уклон гаргана.
- 5.5. Бетон хүчитгэх тор дэвсэж бетон цутгалын ажлыг гүйцэтгэж түүний дараа, гадаргууг дахин хөрсжүүлнэ.
- 5.6. 2 үе хар цаас наах ба хуйлмал материалын зөрүүлэг уклоныг дагуулж 100мм-ээс багагүй нааж хазайлтын хэмжээ 10мм-ээс хэтрэхгүй байна.




Зураг 2. Зөрүүлгийн хэмжээ (жишээ зураг)

- 5.7. Хуйлмал материалыг барилгын парпет, жижиг хийцлэлүүдийн ханын ховил руу 50-100мм цоройлгон нааж, ховилыг битүүмжилнэ.
- 5.8. Дээвэр ба тусгаарлалтын ажлыг -30°C -аас $+60^{\circ}\text{C}$ -ын орчинд гүйцэтгэхийг зөвшөөрнө. (халуун лавмагаар хүрээлэн буй агаар нь -20°C -аас доошгүй орчинд, харин хөлдөлтийн эсрэг хольцгүй усан найрлагатай цийдмэгээр $+5^{\circ}\text{C}$ -аас доошгүй орчинд үйлдвэрлэл явуулна).
- 5.9. Дээврийн ба тусгаарлалтын суурь дээр зураг төслийн дагуу дараах ажлыг зайлшгүй хийх шаардлагатай. Үүнд:
- угсармал хавтангуудын хоорондын заадсыг битүүлэх;
 - температур ашиглалтын заадас гаргах;
 - хавчуулга элементийг тогтоох;
 - тусгаарлалт ба цийдмэг шаваасан дээвэр буюу хуйлмал материал нийлж байгаа дээд талд чулуун бүтээцийн босоо гадаргуугийн дээд хэсгийг шавардах.
- 5.10. Тусгаарлалтын материалыг үргэлжилсэн тэгшхэн үе гарган түрхэнэ. Хатуурч бэхэжсэн гадаргуу дээр будгаас бусад материалаар тэгшлэн тараах замаар үе бүрийг хийнэ. Тусгаарлалтын материалыг бэлтгэхдээ БНБД 31-07-05 “Дээврийн ажил” барилгын норм ба дүрэмд заасан техникийн шаардлагыг баримтална.
- 5.11. Дээвэр болон тусгаарлалтын ажлыг хийхээс өмнө тоног төхөөрөмж угсрахад зориулсан бэхэлгээ, дамжуулах хоолой, кабель зэрэг бүтээцийн уулзвар залгаасыг бетоноор чигжинэ;
- 5.12. Лавмаган тусгаарлагч хэрэглэх гадаргуу ил задгай бол тусгаарлалтын ажил гүйцэтгэх явцад түүнийг чийг авахаас хамгаалсан байна;
- 5.13. Хуйлмал болон цардмал тусгаарлагч хэрэглэх гадаргууг бэлтгэхэд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:
- Угсармал төмөр бетон хавтангийн уулзварыг элс – цементэн зуурмаг буюу жижиг ширхэгтэй бетоноор чигжих (зураг төсөлд зуурмагийн марк заагаагүй байвал 100-аас доошгүй маркийг авна);
 - 20 мм зузаан цементэн зуурмаг буюу 10мм зузаан элсэн дүүргэгчтэй асфальт бетоноор (зураг төсөлд марк заагаагүй бол 50-аас доошгүй маркийг хэрэглэнэ) угсармал төмөр бетон хавтангийн гадаргууг тэгшлэн өнгөлөх;
 - Босоо гадаргуутай тоосгон хэсэгт (хана, утааны суваг яндан гэх мэт) тусгаарлалт хийгдэх өндрийн хэмжээнд шавардах;
 - Цементэн зуурмагийн тэгшилгээ хийх үед температур суултын заадас гаргах;
 - Хуйлмал материалыг босоо, налуу гадаргууд нааж тогтоох уулзварыг зураг төслийн дагуу хийсэн байх;
 - Ус зайлуулах яндан хоолой тогтоох бэхэлгээ элементийг байрлуулах зэрэг болно.
- 5.14. Бетон буюу цементэн тэгшилгээ хиймэгц гадаргууд удаан уурших шингэрүүлэгчээр бэлтгэсэн хөрсжүүлэх дэвсгэр будаг тавина. Дэвсгэр будгийг цементэн тэгшилгээ цутгаснаас хойш 4 цагийн дотор тавихыг зөвшөөрнө. Биежиж хатуурсан буюу хатсан гадаргууд хурдан уурших шингэрүүлэгчээр бэлтгэсэн хөрсжүүлэгчийг 1м 2 гадаргууд 1 л ногдох хэмжээгээр дэвсгэр суурь будаг тавьж шингэрүүлэгч буюу битумэн цийдмэгийн чийгийг бүрэн ууршуулж хатаасан байна.
- 5.15. Органик гаралтай барьцалдуулагч битумийг $+180^{\circ}\text{C}$ хүртэл, давирхайг $+160^{\circ}\text{C}$ хүртэл халааж механик хольцыг нь цэвэрлэж сэврээнэ.
- 5.16. Шаваас болон цийдмэг бэлтгэх битумыг БНБД 31-07-05 “Дээврийн ажил”-д заасны дагуу гүйцэтгэнэ.

5.17. Хуйлмал болон цардмал лавмагаар тусгаарлалт хийхэд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2мм-ээс илүүгүй зузаан шаваас түрхэн
- Хуйлмал материалыг механикжсан аргаар наах тохиолдолд шаваасыг лавмаг суурь гадаргуу дээр нь эсхүл хуйлмал материал дээр нялж түрхэнэ.

5.18. Парпетны малгайвчны уклон 5%-ийн налуутай байна.



Зураг 3. Парпетны малгайвчны налуу (жишээ зураг)

5.19. -20°C хүртэл температуртай хүйтэнд задгай байдалд органик барьцалдуулагч (битум, давирхайлаг шаваас) хэрэглэж дээврийн тусгаарлалтын ажил гүйцэтгэхийг зөвшөөрнө.

5.20. Гадна температур -25°C хүртэл байх үед бетон ба зуурмагт нэмэлт хэрэглэн хөлдөлтөөс сэргийлнэ.

5.21. Дээврийн ажил гүйцэтгэх үедээ хөдөлмөр хамгааллын чанд баримтлан ХАБЭА-аас өдөр бүр зааварчилгаа авч ажиллах.

5.22. Техник, тоног төхөөрөмжийн бүрэн байдлыг шалгаж гэмтэлтэй багаж хэрэгслийг хэрэглэхийг хориглоно.

5.23. Хуучны барилга нь парпетгүйгээс тухайн дээврийг мембрамаар бүрсэн тохиолдолд хүйтний улиралд дээвэрт хүн гарах болон аливаа засвар үйлчилгээ хийхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангагдсаны дараа ажиллана.

6. ДЭЭВРИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕХНОЛОГИЙН ДАРААЛАЛ


6.1. Энгийн дээврийн ажлын хүснэгт 1-д заасан технологийн дагуу гүйцэтгэнэ.

Хүснэгт 1. Энгийн дээврийн ажлын технологийн дараалал

№	Технологийн дараалал	Техникийн шаардлага	Гүйцэтгэх аргачлал	Шалгах
1	Дээвэрт ашиглах дулаалгын материалын бэлтгэл ажил	- Хөнгөн блокийн чийгшил 20%-аас ихгүй байх - Нунтаглалтын хэмжээ 40*40мм-ээс ихгүй байх	- Хөнгөн блокийн жигд хэмжээтэйгээр бутлан 40*40мм-ийн төмөр шигшүүрээр шигшиж эсхүл керамзит ашиглана. - Гадны механик хольц ахуйн хог хаягдлаас цэвэрлэнэ.	Ширхгийн бүрэлдэхүүнд үзлэг хийх, чийгшлийг тодорхойлох
2	Гадаргуугийн бэлтгэл ажил	- Гадаргуугийн өнгөлгөө сайн хийгдсэн байх - Хотгор гүдгэрийн хэмжээ 5мм-ээс ихгүй байна.	- Салхивчны өрлөгийн гадна болон дотор талын битүүмжийг сайтар хийж гүйцэтгэх. - Битүүмжлэлийг сайн хийх /бохирын үнэр гаргагч болон бусад хийцлэлүүд/ - Металл хэсгүүдийн хөрсжүүлж будсан байх. - Гадаргуугийн тэгш байдал хангах хотгор гүдгэр хэсгийг тэгшлэх. - Хог хаягдлыг сайтар цэвэрлэх.	- Битүүмжлэлийг шалгах - Металл хийцлэлийн зэврэлт, хөрсжүүлэлтийг шалгах
3	Гадаргууд хөрсжүүлэгч түрхлэг түрхэх	Гадаргуу тоос, шороогүй байх	- Бэлдсэн гадаргууд хөрсжүүлэгчээ сайтар хутгаж найруулсны дараа 2 үе түрхэнэ. - Хананы цоройлтыг 300мм-ээс багагүйгээр түрхэнэ. - Хөрсжүүлэгч бүрэн хатсаны дараа дараагийн ажлыг гүйцэтгэнэ.	Хөрсжүүлэгч жигд түрхэгдсэн болон бүрэн хатсаныг шалгана
4	Уур, ус тусгаарлагч дэвсэх	- Хуйлмал материалын зөрүүлэг 100мм-ээс багагүй байх - Хазайлтын хэмжээ 1см-ээс хэтэрч болохгүй	- Бэлтгэгдсэн гадаргууд уур, ус тусгаарлагч материалыг наахаас өмнө 1 цагийн өмнө дэлгэж бэлтгэн 100мм-ээр ам зөрүүлэн тэгшлэн наана. - Барилгын парпет, жижиг хийцлэлүүдийн хана руу 50-100мм цоройлгон наана. - Налуу талаас уур, ус тусгаарлагчийг наана. Парпет, жижиг хийцлэлүүдэд цоройлгон наахдаа заавар хөрсжүүлэгч түрхэж шаваас наана.	Уур, ус тусгаарлагчийн наалтыг шалгах
5	Хөөсөнцөр хавтангаар дулаалга хийх	- Хөөсөнцөр хоорондын зайн хэмжээг 5мм-ээс ихгүй байх - Нягтрал сайтай хөөсөнцөр хавтангуудыг зөрүүлэн дэвсэх	- Гадаргууд хөөсөнцөр хавтанг сайтар шахаж дэвсэнэ. - Хийцлэлүүдийн хана хөөсөнцөр хавтанг хооронд дахь зай завсрыг шингэн хөөсөөр битүүмжилж өгнө.	- Хавтангуудын зөрүүлгийг шалгах - Завсар хоорондын зайг битүүмжилсэн эсэхийг шалгах
6	Хөнгөн блокийн нунтаг, керамзитаар дулаалга хийх	- Зураг төсөлд заасан хэмжээний дагуу налууг гаргана - Хөнгөн блок нь хуурай, жигд ширхэгтэй байна	- Налуулгийн хэмжээг утас татаж гаргах. - Керамзит, жигд нунтагласан хөнгөн блокийн үймэгийг хөөсөнцөр хавтан дээрээ зургийн дагуу тарааж дэвсэнэ. - Тусгайлан бэлдсэн давтагчаар нягтруулна.	Төмөр рейкээр налуугийн дагуу болон хөндлөн чигээр шалгах

7	Бэлтгэл бетоны хүчитгэх тор дэвсэх	Бетон зуурмагийг хагарлаас урьдчилан сэргийлэх, хуйлмал тороор хүчитгэх	- Зориулалтын хуйлмал торыг дэвсэхдээ зөрүүлгийг 150-200мм-ээр зөрүүлж дэвсэнэ - Богино торыг арматурын нарын төмөр утсаар холбож бэхэлнэ	Торны зөрүүлгийг шалгах
8	Бэлтгэл бетоны ажил	- Бетон зуурмаг зурагт заасан маркийн дагуу байх - Нарийн өнгөлгөө хийгдсэн байх - Бетоныг хатсан үед нь цементэн сүүгээр өнгөлөхийг хориглоно	- Зурагт заасан налуулга дагуу утас татаж маяк тавина. - Зуурмагийг сайтар тарааж, нягтруулж, рейкээр тэгшилнэ - Тодорхой хэмжээнд суулт авсны дараа нарийн өнгөлгөө хийнэ - Чийг гадагшлуулах хоолойг суурилуулна	Бетоны хагарал, цууралт, өнгөлгөө, налууг шалгах
9	Хаяавч бетоны ажил	- Ан цав цууралтгүй байх - Хаяавчны налууг 45° гаргах - Хаяавч бетоны өндөр 100мм-ээс багагүй байх	- Дээврийн шал, хананд зургийн дагуу хэмжээ тавина - Хэмжээсний дагуу жигд нэг түвшинд хаяаг хийж, өнгөлөх	Хаяавчны налууг шалгах
10	Бетоны арчилгаа	- Бетоны чанарыг алдагдуулахгүй байх - Бетонд хагарал, ан цав үүсэхгүй байх	- Нарны хэт халалтын үед бетон чийгшлээ огцом алдахаас сэргийлж хучих, усаар жигд норгох. - Хүйтний үед нэмэлт халаагуур хэрэглэх, хучих, бетон зуурмагийн нэмэлт хийх зэргээр хамгаална.	Тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалж бетон бэхжилтийг хянаж шалгана
11	Хөрсжүүлэгч хийх	- Бэлдсэн гадаргууд хөрсжүүлэгчээ сайтар хутгаж найруулсны дараа 2 үе түрхлэг түрхэнэ - Хаяаны цоройлтод хөрсжүүлэгч 500мм-ээс багагүйгээр түрхэж өгнө	- Бэлдсэн гадаргууд хөрсжүүлэгчээ сайтар хутгаж найруулсны дараа 2 үе түрхлэг түрхэнэ. - Хананы цоройлтод хөрсжүүлэгчийг 500мм багагүй түрхэж өгнө. - Хөрсжүүлэгч бүрэн хаталтаа авсны дараа дараагийн ажилбарыг хийнэ.	Хөрсжүүлэгч гадаргууд жигд түрхэгдэж, бүрэн хатсан байна
12	2 үе хар цаас наах	- Яндан, усны цоргоны хэсгийг шингэн шилэн хуйлмалаар наах - Хар цаасыг үечлэн ан цав гаргахгүй наасан байна	- Ажлын талбайн гадаргуу цэвэрлэнэ - Хуйлсан хар цаасыг наахаас 30мин өмнө дэлгэж гадаргууг сайтар цэвэрлэсэн байна. - Хар цаасыг урсгалтын эсрэг чиглэлд зөрүүлж наана. - Хар цаасны зөрүүлгийн дээрээс доош чиглэлд 10см-ын зөрүүлэгтэй сайтар наана. 1-р үеийн хар цаасыг хөндлөн чиглэлд 2-р үеийн хар цаасыг уртын дагуу	Тавигдах шаардлагын дагуу хар цаасны зөрлөг 10см-ээс багагүй эсэхийг шалгах
13	1 үе чулуутай хар цаас наах	Хар цаасыг ан цав гаргахгүй наасан байх	3-р үеийн чулуутай хар цаасыг мөн эсрэг чиглэлд наана. - Хар цаасны зөрүүлгийг үе тутамд праймороор 5см-ийн өргөнтэй битүүмж түрхлэг түрхэнэ.	- Тавигдах шаардлагын дагуу хар цаасны зөрлөг 10см-ээс багагүй эсэхийг шалгах - Хөндий наасан эсэхийг шалгах

14	Цоройлтын ирмэгийг хамгаалах	Цоройлтын ирмэгийг хамгаалах	- Дулаалгын үеэс 300-500мм зайд хар цаасны дээд ирмэгийн дагуу ханыг ховил гарган зүсэж Г хэлбэрийн төмрийг тогтооно. 2 метр төмөрт 500-600мм-ийн алгасалтай хадна.	Хар цаасны ирмэг сайн дарагдсан эсэх, төмөр ханын ховил руу гүйцэд орсон эсэхийг шалгах
15	Малгайвч өмсөх	Борооны ус хана дагаж урсахгүй байх	Парпетны дээд ирмэгт малгайвч өмсгөн сайтар бэхэлж эргэн тойрны зай завсрыг силикондож битүүмжилнэ.	Бэхэлгээ, битүүмжийг шалгана.



Зураг 4. Цоройлтын ирмэг болон малгайвч

6.2. Бетон цутгалтын бэлтгэх ажлын технологийн дараалал хүснэгт 2-т заасны дагуу хийнэ.


Хүснэгт 2. Бетон цутгалтын бэлтгэх ажлын технологийн дараалал

№	Технологийн дараалал	Технологийн шаардлага	Гүйцэтгэх аргачлал	Шалгах	Хүлцэх алдаа
1	Битум дэвсэх	Нийт талбайд зай завсар үүсгэхгүйгээр жигд дэвсэх	Уур, ус тусгаарлагч материалыг бетон цутгах талаас эхлэн уртын дагууд дэвсэн 100мм зөрүүлэн үечлэн наана.	Уур тусгаарлагчийн бүрэн бүтэн эсэх болон зөрүүлгийн хэмжээг шалгах	
2	Налуугийн түвшин татах	Ажлын зургийн дагуу налууг ус тогтохооргүй гаргах	Ус цуглуулах нүхний ирмэгээс парпет хүртэл уурагт өгөгдсөн налууг гаргах	Налуулгийн түвшний хэмжээ болон чиглэл ажлын зурагтай тохирч байгаа эсэхийг шалгах	±5мм
3	Маяк тавих	Бетон цутгалтын налуугийн түвшинг ажлын зургийн хэмжээнд барих	Маякийг цутгах түвшинд тэгш байрлуулан цутгах заагыг гаргаж өгнө	Маяк тавьсан түвшингүүдийг нивелирдэн шалгана.	±2.5мм

Нэмэлт: Ил болон далд ажлыг фото зургаар баталгаажуулсан байна.

7. ХУЙЛМАЛ МАТЕРИАЛАН ДЭЭВЭР БА ТУСГААРЛАЛТ

- 7.1. Тусгаарлалтын материалыг түрхэхийн өмнө суурийг тосгүйжүүлэх ажлыг хийнэ.
- 7.2. -20°C хүртэл хүйтэнд хуйлмал материалаар дээврийн ажил гүйцэтгэхийг зөвшөөрнө.
- 7.3. Хасах температурт цардмал дээврийн ажил гүйцэтгэхийг хориглоно.
- 7.4. Шаваасан үеийг агаарын температур $+5^{\circ}\text{C}$ -ээс доошгүй нөхцөлд шингэрүүлэх бөгөөд гадна температураас хамааруулан шингэрүүлэлтийг хуйлмал дээврийг наахтай зэрэгцүүлж эсхүл өмнө нь хийнэ.
- 7.5. Хучилт нь угсармал болон цутгамал төмөр бетон байвал бетон зуурмагаар тэгшилгээний үеийг заавал хийнэ. М50-М100 маркийн бетон зуурмагийг 10-20см зузаантайгаар асгаж тэгшилнэ.
- 7.6. Гадаргууг дулаан тусгаарлах хөөсөн хавтангуудаар бүрсэн бол бетон зуурмагийн тэгшилгээг 25-30мм зузаан хийнэ.



Зураг 5. Бетон зуурмагийн тэгшилгээ (жишээ зураг)

- 7.7. Хуйлмал материалаар энгээр нь дээвэр хийхдээ: Хуйлмал материалаар уртааш энгээр нь дороос дээш чиглэлээр наана. Дээврийн налуу 15%-аас бага тохиолдолд усны хоолойд перпендикуляр, дээврийн налуу 15%-аас их тохиолдолд усны хоолойн чиглэлээр тус тус гүйцэтгэнэ.
- 7.8. Дээврийн болон тусгаарлалтын хуйлмалыг солбицуулан наахыг зөвшөөрөхгүй.
- 7.9. Шиллэг сүлжмэл дээвэр юм уу тусгаарлалт хийхдээ халуун шаваасыг түрхэнгүүт долгион үүсгэхгүйгээр дэлгэж наах хэрэгтэй. Халуун шаваасны зузаан 2 мм-ээс багагүй байна. Өмнө нь хийсэн халуун шаваас хөрсний дараа дараагийн үеийг мөн адил гүйцэтгэнэ.
- 7.10. Тэгшилгээн дэх температур агшилтын заадас, хучилтын хавтангуудын хоорондох уулзварыг 150 мм хүртэл өргөнтэй хуйлмал материалаар хучих ба заадас (уулзвар)-ын нэг талаас наана.
- 7.11. Дээврийн налуугийн дагуу хуйлмал материалыг энгээр нь наах үед энгийн дээд хэсэг нь эсрэг талын налуугийн 1000 мм-ээс багагүй хэсгийг хучсан байх ёстой. Дэлгэгдэж буй хуйлмал материалын дор шаваасыг 80мм-ээс 100 мм өргөнтэй гурван туузан зурвасаар шууд түрхэнэ.
- 7.12. Дээврийн налуу хөндлөнг энгээр нь наахдаа дээврийн нуруу мод дээр тавих үе бүрд

дээд хэсэг нь дээврийн эсрэг налууг 250 мм хучсан байх ба шаваасыг нэлэнхийд нь түрхсэн үе дээр наана.

7.13. Хуйлмал материалан тусгаарлалт ба дээвэр хийхдээ “БНБД 31-07-05 Дээврийн ажил”-д заасны дагуу байна.

7.14. Дээврийн цаваг хар цаас тус бүрийн уулзваруудын ам дарах хэмжээг доор дурдсанаар авна. Үүнд:

- 2.5% ба түүнээс дээш налуутай дээвэрт наах цавгийн энэхүү давхаргын өмнө наасан хэсгийн ирмэгтэй уртын дагууд 100 мм, цаваг цаасны энгээр хөндлөн чигт доод талын давхаргад 70 мм, дээд талын давхаргад 100 мм тус тус зөрүүлдсэн байхаар;
- нааж буй давхаргын хөндлөн ба дагуу залгааснууд нь доод талын давхаргын мөн залгаасуудаас хажуу тийш 300 мм-ээс багагүй зайтай байна.

7.15. Өвлийн улиралд дээврийн тэгшилгээ үеийг элсэн дүүргэгчтэй асфальт бетоноор цутгаж хийнэ. Ус цементийн харьцаа нь 2:1 элс, цементэн зуурмагаар тэгшилгээ үе хийхийг зөвшөөрнө.

7.16. Хасах температуртай үед дээврийн хуйлмал материалыг зөвхөн хүйтэн лавмагаар наана.

7.17. Дээврийн хар цаас наах ажил дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- дээврийн бодит налуу зураг төсөлд заасан налуугаас 5%-аас илүү зөрүүтэй байж болохгүй;
- дээврийн гадаргуу гадна ба дотор ус зайлуулагчаар хур борооны усыг бүрэн зайлуулах боломжтой байх;
- хуйлмал материалыг бат бэх наалдсан эсэхийг давхарга бүрд захаас нь хуулж шалгана /Хуулахад наалтаараа ховхрохгүй урагдаж байвал наалтыг сайн болсон, хуйлмал материал наалтаараа ховхорч байвал чанаргүй гүйцэтгэсэн гэж үзнэ/.

8. ЦИЙДМЭГ БИТУМЭН БА ПОЛИМЕРЕН МАТЕРИАЛААР ДЭЭВЭР БА ТУСГААРЛАЛТ ХИЙХ

8.1. Цийдмэг – шаваасан материалан дээвэр ба тусгаарлалт хийхдээ дэвсгэр буюу доод үе бэхэжсэний дараа шаваасыг тусгаарлалтын хуйлмалын үе бүрд тэгш зузаантай нэлэнхийд нь тасархай гаргахгүй түрхэнэ.

8.2. Шилэн ширхэглэлд шөрмөсөөр бэхжүүлсэн цийдмэг – шаваасан материалаар дээвэр ба тусгаарлалт хийхдээ тусгаарлалтын бүрээсний нягтрал ба бүрэлдэхүүндээ жигд хуваарилагдах, ширхэглэлийн урт нь ижил байх нөхцөлийг хангадаг агрегатын аргаар гүйцэтгэнэ.

8.3. Цийдмэг болон полимер бүрэлдэхүүнтэй шаваасан дээвэр ба тусгаарлалт хийхдээ 3 дугаар хүснэгтийн шаардлагыг сахих ёстой. Дээврийн нийлэх залгааг хуйлмал дээвэр хийхтэй адил гүйцэтгэнэ.

8.4. Битумокерамзит ба битумперлит болон халуун асфальтан холимог, цементэн зуурмагаар тусгаарлалт хийхдээ “БНБД 31-07-05 Дээврийн ажил”-д заасан шаардлагад нийцсэн байна.

9. ДУЛААЛГЫН МАТЕРИАЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

9.1. Дулаан дамжилтын илтгэлцүүр нь 0.05Вт/м.оС–ээс бага байх материалыг барилгын дулаан тусгаарлах буюу дулаалгын материалд тооцно.

- 9.2. Хөөсөнцөр хавтанг ус чийгийн шууд нөлөөлөлд орж болох газартай харьцаж буй хэсэгт хэрэглэхийг хориглоно.
- 9.3. Дулаалгын материалыг уулзвар хооронд нь зай завсаргүйгээр угсарсан байна.
- 9.4. Нано дэвшилтэт технологийн шингэн керамик, дулаан тусгаарлагч Корунд бүтээгдэхүүн нь цанталт, мөөгөнцөр, жиндэлт, хайралт, сийгэлт зэрэг дулаан алдагдлын асуудлыг будаг шиг түрхэж жилийн аль ч улиралд ашиглах боломжтой байна.
- 9.5. Нано буюу дэвшилтэт технологийг цэвэр хүйтэн усаар хутгаж шингэлнэ. 2л савлагаанд 100-150гр ус хийж шингэлэхээр тооцно. Хүйтэн гадаргууд 1мм зузаан буюу 2 үе, цантаж мөөгөнцөртдөг хэсэгт 2мм зузаан буюу 4 үе давхарлан будна.
- 9.6. Бетонон дээвэр дээр тавигдсан чулуулаг, хөөсөн полистиролын хуудас хэлбэрээр дулаан тусгаарлагчтай байна.
- 9.7. Дулаан тусгаарлах ноосон материал нь хүснэгт заасан техникийн үзүүлэлтийг хангасан байна.

Хүснэгт 3. Дулаан тусгаарлах ноосон материалын техникийн үзүүлэлт

ҮЗҮҮЛЭЛТИЙН НЭР ХЭМЖИХ НЭГЖ	ЦЭВЭР НООСОН МАТЕРИАЛ	ХОЛЬЦТОЙ НООСОН МАТЕРИАЛ	СТАНДАРТ АРГАЧЛАЛ
Эзлэхүүн нягт, кг/м ³ ,	40	30	MNS ISO 29470-2010
Дулаан дамжуулалтын илтгэлцүүр, Вт/ мК, ихгүй	0,039	0,042	MNS ISO 3442-2002
Ус шингээлт, %, ихгүй	35	30	MNS ISO 29470-2010
Химийн ширхэгтийн агууламж, %, ихгүй		40	MNS ISO 4010:2009
Суналтын бат бэх	Өөрийн жингээс хоёр дахин их ачаалал даах	Өөрийн жингээс хоёр дахин их ачаалал даах	MNS ISO 29470-2010
Чийг, %, ихгүй	16	16	MNS ISO 380:2007
Бичил биет, шавжийн үйлчлэл	Тэсвэртэй	Тэсвэртэй	ISO 3998
Гал тэсвэрлэлт	Е-ангиллаас багагүй	Е-ангиллаас багагүй	MNS EN 13501-1 2013

10. УС ТУСГААРЛАЛТ

- 10.1. Хавтгай дээврийн суурь гадаргууг тэгшлэх, түүнийг химийн үйлчлэлээс хамгаалах зорилгоор полиэтилен гялгар цаас, полиэстер цэмбэ, хөөсөн хуйлмал, тостой хуйлмал
- 10.2. Зураасан зам гаргаж наахад нийт талбайн 10-15%-ийг цавуудсан байх, цэгэн хэлбэрээр цавуудаж наахдаа 1м.кв талбайд 4ш тавгийн хэмжээтэй цавуун түрхлэг хийж наана.
- 10.3. Ус тусгаарлагчид халуун ба хүйтэн битумэн лавмаг, нийлэг давирхайн гаралтай будаг хэрэглэх бөгөөд будгийг бүх тусгаарлах гадаргууд хоёроос цөөнгүй давхарлаж жигд түрхэнэ. Эхний түрхлэг бүрэн хатаж хатуурсны дараа дараах үеийг будаж, үе тус бүрийн зузаан нь 2мм орчим байна.
- 10.4. Агаарын температур +25°С–аас дээш үед наамал ус, уур тусгаарлалтын ажил гүйцэтгэхэд нарны хурц төөнөлт, хайлж урсахнаас хамгаална.
- 10.5. Босоо ба 25°С-аас дээш налуу гадаргууд урьдчилан тайрсан хуйлмал материалыг 1.5м–ээс 2м уртад дороос дээш чиглэлээр наана. Лавмагийг эхлээд тусгаарлах гадаргууд, дараа нь хуйлмал материалд түрхэнэ.

- 10.6. Байгууламжийн газар доорх хэсгийн гадна талын хуйлмал ус тусгаарлагчийн төгсгөлийг тусгаарлах талбайн эргэн тойрон босгосон 1.2м-ээс 1.5м өндөртэй түр зуурын хананд буюу гадна ханын эргэн тойронд түүнээс 0.5м-ээс 0.6м цухуйх бетон дэвсгэрт наах хэрэгтэй.
- 10.7. Тусгаарлагч хийх гөлмөн төмрийг тэгшилж хэмжиж, зэвнээс цэвэрлэнэ. Төмрийг өнцөгт хэлбэртэй бэлтгэх ба диагналуудын ялгавар 6мм-ээс хэтэрч болохгүй.
- 10.8. Бэлэн халуун асфальтан хольцоор ус тусгаарлалтыг босоо гадаргууд 20м хүртэл тууш 1.4м-ээс 1.8м өндөртэй хэсэгчлэн дороос дээш нь 5мм-ээс 7мм зузаан давхаргаар түрхэж өгнө. Харин хэвтээ гадаргууд 7мм-ээс 10 мм зузаантай байна. Түрхээсүүдийн уулзвар залгаасыг 200 мм-ээс багагүй өргөнтэй, хажуу тийш 300 мм-ээс багагүй зайтай зөрүүлж түрхэнэ.
- 10.9. Уур, ус тусгаарлалтын ажил гүйцэтгэхдээ үе тус бүр болон хийгдэж дууссан тусгаарлагчийн бохирдохоос хамгаалах шаардлагатай. Битумд шингээсэн дайргаар ус тусгаарлагч хийхдээ БНБД 3.06.03-88-ыг баримтална.
- 10.10. Хамгаалалтыг шавраар хийхдээ 50 мм-ээс 100 мм зузаан үеэр нягтруулж гүйцэтгэнэ. Өвлийн улиралд шавар хэрэглэхээр бол +15°C-аас дээш халаасан байна.
- 10.11. Дээврийн тусгаарлалтын уулзвар залгаас, заадлыг БНБД 31-04-05-д заасны дагуу гүйцэтгэнэ.

11. ШАЛГАХ ХУУДАС

Орон сууц олон нийтийн барилга, байгууламжийн дээврийн засвар, шинэчлэлтийн ажлын хүснэгт 4-д заасны дагуу хянаж, шалган хүлээн авна.

Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Уур, ус тусгаарлалтын болон хамгаалалтын үе давхаргын ажлыг хүлээн авах үед гүйцэтгэгч байгууллага далд ажлын актыг үйлдэж зургаар баталгаажуулсан эсэх	☐	☐
2	Хавтгай дээврийн гадаргуугийн өнгөлгөө сайн хийгдсэн болон хотгор гүдгэрийн хэмжээ 5мм-ээс ихгүй эсэх	☐	☐
3	Хуйлмал материалын зөрүүлгийг 100мм-ээс багагүй хийсэн эсэх	☐	☐
4	Хавтгай дээврийн хаяавчны налууг 45° гаргасан эсэх	☐	☐
5	Бэлдсэн гадаргууд хөрсжүүлэгчээ 2 үе түрхлэг түрхсэн эсэх	☐	☐
6	Хаяавчны налууг 45° гаргаж хаяавч бетоны өндөр 100мм-ээс багагүй байгаа эсэх	☐	☐
7	Хаяаны цоройлтод хөрсжүүлэгч 500мм-ээс багагүйгээр түрхэж өгсөн эсэх	☐	☐
8	Дээврийн дулаалгын материал стандартын шаардлагад нийцэж байгаа эсэх	☐	☐
9	Дулаалгын үеэс 300-500мм зайд хар цаасны дээд ирмэгийн дагуу ханыг ховил гарган зүсэж Г хэлбэрийн төмрөөс дарж тогтоосон эсэх	☐	☐
10	Парпетны дээд ирмэгт малгайвч өмсгөн сайтар бэхэлж эргэн тойрны зай завсрыг силикондож битүүмжилсэн эсэх	☐	☐
11	Дээврийг усаар ачаалж ус нэвчиж байгаа эсэхэд хяналт тавих	☐	☐

Тайлбар: Дээрх шалгуур үзүүлэлтийг хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БНБД 31-07-05 Дээврийн ажил;
- БНБД 31-02-03 Дээврийн хучлага;
- MNS EN 13163:2011 “Барилгын дулаан тусгаарлах материал Хөөсөн полистрол (EPS) бүтээгдэхүүн. Техникийн шаардлага”;
- MNS 6227:2010, Барилгын дулаан тусгаарлах материал-Эрдэс хөвөн ба хөөсөн полистирол (PS) дулаалгатай олон үет төмөр хавтгайлж. Техникийн шаардлага;
- “Налуу дээвэр угсралт” Чадамжийн гарын авлага 2020;
- “Дээврийн дулаалга хийх” Чадамжийн гарын авлага 2020;
- “Хавтгай дээвэр угсрах” Чадамжийн гарын авлага 2020.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар